



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Шаардлага, шалгуур үзүүлэлт  
тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2003 оны "Дүрэм батлах тухай" 276 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм"-ийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээчид тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хавсралт ёсоор шинэчлэн тогтоосугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны "Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 123 дугаар тушаалын 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



Л.ГАНТӨМӨР

091793

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын  
2016 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн  
...../13 дугаар тушаалын хавсралт



## БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ШИНЖЭЭЧИД ТАВИХ ШААРДЛАГА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн /цаашид “БМИҮЗ” гэх/ шинжээчид магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, ажил олгогч байгууллага, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, оюутны өөрөө удирдах байгууллагаас нэр дэвшүүлж болно.
2. БМИҮЗ шинжээчид тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг харгалзан шинжээчийг шалгаруулж боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
3. Дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаас шинжээчид нэр дэвшиж буй иргэн дараах шаардлагыг хангасан байна.
  - 3.1. Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс ахлах багш, дэд профессорын ангиллын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан
  - 3.2. Боловсролын доктороос /Ph.D/ доошгүй зэрэгтэй
  - 3.3. Боловсрол судлалын асуудлаар судалгааны ажил хийж, ном товхимол хэвлүүлсэн, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл нийтлүүлсэн байх
  - 3.4. Сургалтын арга зүй, технологи, кредит систем, хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын асуудлаар мэргэшсэн, гадаад болон дотоодод энэ чиглэлээр сургалт, семинарт хамрагдаж, олон улсын чанартай арга хэмжээнд оролцож байсан бол давуу тал болно.
4. Ном зүйчид нэр дэвшиж буй иргэн дараах шаардлагыг хангасан байна:
  - 4.1. Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй,
  - 4.2. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын болон мэргэжлийн, төрөлжсөн номын сангуудад 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжил дээшлүүлсэн,
  - 4.3. Мэргэжлээрээ ном, товхимол, гарын авлага хэвлүүлсэн байвал давуу тал болно.
5. Шинжээчид нэр дэвшиж буй оюутан дараах шаардлагыг хангасан байна:
  - 5.1. Сурлагын голч дүн нь 2.5-аас доошгүй байх
  - 5.2. Бакалаврын хөтөлбөрт хамрагдаж буй өдрийн ангийн оюутан байх.
6. Аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагаас шинжээчид нэр дэвшиж буй иргэн дараах шаардлагыг хангасан байна:
  - 6.1. Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй
  - 6.2. Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан
  - 6.3. Мэргэжлийн холбооны гишүүн байх

6.4. Боловсрол судлал, мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил хийж, ном товхимол хэвлүүлсэн, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл нийтлүүлсэн байвал давуу тал болно.

7. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор шинжээчийн эрх олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

--- оОо ---